



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/АЗ-1

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" XXV/05 дугаар тогтоолын 06 дүгээр хавсралтын 17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хангал сумын цэвэр усны даралтат цамхаг барих 3 дугаар шат (одоо газар дээр гарсан гүний худгаас-2 дугаар өргөлтийн усан сан төлөвлөж даралтат цамхгийг усаар хангах) зураг төсөв боловсруулах ажлыг 19,900,900 (арван есөн сая есөн зуун мянга есөн зуун) төгрөгөөр "Эрч булаг лайн" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Эрч булаг лайн" ХХК-ийн захирал (Э.Янжинлхам)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д тус тус даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний "цэвэр усны даралтат цамхаг барих 3-р шатны ажил (Хангал сум)" төсөл арга хэмжээнээс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011060